ДААТГАЛ
SINCE 1994

2022

ЖИЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот



ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Ердийн даатгалын салбарын өнөөгийн байдал

АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн танилцуулга
Түүхэн товчоон
Онцлох үйл явдлууд
Даатгалын үйл ажиллагаа

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
Хувьцааны арилжааны мэдээ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлага
Давхар даатгал
Нөхөн төлбөр

ХҮНИЙ НӨӨЦ

Хүний нөөц

2022 ОНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Санхүүгийн байдлын тайлан

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЕРДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

/2022 оны байдлаар/

15 ердийн даатгалын компани	**2** урт хугацааны даатгалын компани	**1** дотоодын давхар даатгалын компани
63 даатгалын зуучлалын компани	**25** даатгалын хохирол үнэлэгч компани	**2,403** даатгалын төлөөлөгч

ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө тайлант хугацаанд 474.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.5 тэрбум төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого, түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм.

Даатгалын салбарын нийт хөрөнгө */тэрбум төгрөг/*



Ердийн даатгалын нийт хураамжийн орлого
/тэрбум төгрөг/



Ердийн даатгалын нийт хөрөнгө
/тэрбум төгрөг/



Ердийн даатгалын компаниуд 2022 онд 298 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55.4 тэрбум төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн байна. Нийт хураамжийн сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 13 хувьтай байна. Нийт хураамжаас 7.8 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийгдэж, 99.9 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулснаар даатгалын цэвэр хураамжийн орлого 188.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нийт нөхөн төлбөр
/тэрбум төгрөг/



Нийт нөөц сан
/тэрбум төгрөг/



Тайлант хугацаанд нийт 93 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 тэрбум төгрөгөөр буюу 28 хувиар өссөн ба 377 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээ бүхий эрсдэлийг хүлээн авч үүнээс тодорхой хувийг нь давхар даатгалын компанид шилжүүлжээ.

Давхар даатгалын зардал

/тэрбум төгрөг/



Компаниуд хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах хандлага жил ирэх тусам нэмэгдэж, 99.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг давхар даатгалд шилжүүлсэн байна.

Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр

/тэрбум төгрөг/



Мөн нийтдээ давхар даатгагчаас 8.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг төлүүлсэн байна.

АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Ард Даатгал компанийн хувьд Монгол улсын компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) - ноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа явуулж буй (Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар - 2/16) хувьцаат компани юм.

Бидний үйл ажиллагаа нь Иргэний хууль, арилжааны даатгалын холбогдолтой хуулиуд болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан даатгалын багц дүрмээр зохицуулагддаг ба тус компани нь даатгалын компанийн хувьд зөвхөн даатгалын үйлчилгээ эрхэлдэг төдийгүй Даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйл болон 49 дүгээр зүйлд заасны дагуу эрх, үүргээ хүлээн ажилладаг юм.

Ард Даатгал ХК нь 2018 онд IPO хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаас гаргагчид холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж байгаа билээ.

Тус компани нь 1994 онд Монгол Улсын ууган даатгалын компани болон байгуулагдаж, даатгалын зах зээлд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.

ТҮҮХЭН ТОВЧООН

1994

Анхны хувийн даатгалын компани болов.

2004

Их Британийн Omni Whittington Group хөрөнгө оруулагч болов.

2010

International Quality Era Award (Switzerland, Geneva) шагнал гардав.

2011

Даатгалын салбарт анх удаа нэгдэх процесс явагдаж, Гранд Даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэв.

2012

Гранд Экспо-ийн Оны Шилдэг Даатгалын компани болов.

2014

Монгол Улсын Татварын Ерөнхий Газрын дээд шагнал Хөх дэвтэр шагнал гардав.

2015

Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулагч болов.

2013

МҮХАҮТ-ын Оны Шилдэг Даатгалын компаниар 3 жил дараалан шалгарав.

2011

Оюу толгой төслийн бүтээн байгуулалтад оролцож эхлэв.

2010

Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээ нэвтрүүлэв.

2008

Санхүүгийн Зохицуулах Хорооны Оны Шилдэг Даатгалын компаниар шалгарав.

2000

Монгол Улсын ТОП-5 даатгалын компанийн нэг болов.

1994

Ард Даатгал ХК үүсгэн байгуулагдав.

2016

Малын Индексжүүлсэн Даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.

2017

MSH International Олон Улсын эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлж эхлэв.

2018

IPO хийж нээлттэй хувьцаат компани болов.

2019

АрдКойн урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.

2020

Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст 3 жил дараалан багтав.

2021

Даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулав.

2022

Гадаадад зорчигчдын даатгалын хамгаалалтад Ковидын эрсдэлийн хамгаалалтыг багтаалаа.

2016

Давхар даатгалын ТРИТИ гэрээг ХБНГУ-ын давхар даатгагч Ханновер Ре-тэй байгуулав.

2017

Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХХК-тай хамтран Тариалангийн даатгал хэрэгжүүлж эхлэв.

2019

Ард Апп-д даатгалын цэс нэмэгдэж, аппаар даатгал хийж эхлэв.

2020

Ковид-19 цар тахлын хамгаалалт бүхий шинэ даатгалын бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэв.

2020

Олон улсын болон үндэсний хэмжээний бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдэд даатгагчаар оролцож байна.

2021

Хувьцаа эзэмшигч дийн тоо нэмэгдэж, 10,151 болов.

2022

Харилцагчийг ангилан, мэдээллийн бааз үүсгэх CRM системийг хэрэгжүүлж эхлэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

MSE: ATC

8,142
Хувьцаа эзэмшигчиддээ

₮1 тэрбум
Ногдол ашиг тараалаа

Хувьцаа эзэмшигчиддээ 1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваариллаа.

Монгол Улсын 5 том арилжааны банк, мэргэжлийн зуучлагчийн тусгай зөвшөөрөл бүхий 30 гаруй компани, мөн тооны банк бус санхүүгийн байгууллагатай даатгалын зуучлалаар хэд хэдэн төрлийн даатгалын хэлбэрүүдээр хамтын ажиллагаагаа шинэ шатанд гарган, өргөжүүлэх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна.

Даатгуулагчийг урамшуулах ажлын хүрээнд иргэд болон байгууллагад даатгалын хураамжийн орлогын хувь хэмжээгээр тооцон АрдКойны урамшуулал олгон ажиллав.

2022 оны турш давхардсан тоогоор нийт 156 байгууллагын 4,680 хүнийг хамруулсан зөвхөн Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг таниулах, даатгуулсан харилцагчдаа халамжлах, зөвлөгөө мэдээллээр хангах сургалтыг зохион байгуулжээ.

2019 оноос хойш Ковидын улмаас завсарлаад байсан Сингапурын Олон Улсын Давхар Даатгалын Конференц 2022 оны 10 сарын 31 ээс 2022 оны 11 сарын 3-ны өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулагдаж манай компанийн төлөөлөл биечлэн оролцож Miller, Swiss Re, Munich Re, Howden, UIB, JB Boda, Gallagher re, Canopius, China Re, Kuwait re зэрэг давхар даатгагч, брокеруудтай уулзаж гадаад хамтын ажиллагаагаа бэхжүүлэв.

Ард Даатгал компанийн стратегийн түнш болох ХБНГУ-ын Аллианц (Allianz) компанийн Сингапур улсад зохион байгуулсан олон улсын сургалт семинарт оролцож бизнесийн хүрээг тэлэх, зах зээлийн хувь оролцоог нэмэгдүүлэх боломжуудыг хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах суурийг тавьлаа.

Иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулж Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран "Даатгалын зах зээлийн сорилт ба шийдэл" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон.

Даатгуулагчийн хамтын ажиллагааны үр дүнгээс хамааруулж харилцагчийн ангилалтай болгосноор даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, таатай нөхцөлөөр хүргэх боломжтой болгов.

Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ажиллах хүрээнд олон улсын тэмцээнд оролцсон өсвөрийн хөлбөмбөгийн тамирчдыг дэмжин хамтран ажилласан.

Жудо бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчдыг олон улсын тэмцээнд дэмжин хамтран ажиллалаа.

"Даатгал бидний амьдралд" сургалтыг тогтмол давтамжтайгаар олон нийтэд зохион байгуулж иргэдэд даатгалын тухай, түүний ач холбогдлыг таниулахыг зорин ажиллалаа.

Нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 7,675 даатгалын тохиолдолтой холбоотой 7.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж өмнөх жилээс 60 гаруй хувийн өсөлттэйгээр даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүлж ажиллалаа.

1 хоногт шийдвэрлэдэг нөхөн төлбөр **21** **тохиолдол**

Сүүлийн 3 жилд олгосон нөхөн төлбөр **17.5** **тэрбум ₮**

Ахмадын асрамжийн төвд сувилуулж буй ахмадууд болон Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүдэд нэн шаардлагатай байдаг асрахуйн хэрэгслүүдийг гардуулан өгснөөс гадна хамт олноо тэргүүлэн ажиллаж буй сувилагч нарт Ардын Тэтгэврийн Данс компанийн Тэтгэврийн хуримтлалыг нээн өгч, ирээдүйгээ өмчлөхөд нь нэг алхмаар ойртууллаа.

Монголын даатгалын салбар үүсч хөгжсөний 82 жилийн ойг тохиолдуулан "Замын хөдөлгөөнд соёлтой оролцьё " үйл ажиллагааг зохион байгуулж, дүрмээ баримтлан замын хөдөлгөөнд оролцохыг жолооч нартаа уриалан, мөн урамшуулан ажиллалаа.

Мөн Улсын Нийгмийн даатгалын санд 500 сая, татварт 1.2 тэрбум төгрөг төлсөн байна.

Ард Даатгал ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө бизнесийн ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна.

Ард Даатгал компанийн зүгээс харилцагч байгууллагууддаа гэрээний хугацаанд даатгалын тохиолдолд болон эрсдэлийг удирдахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг. Энэхүү ажлын хүрээнд даатгалын үйл ажиллагааны шинжилгээг хагас жил тутамд хийж, учирсан эрсдэлүүдэд харьцуулсан судалгаа гаргаж, түүнд тохирсон зөвлөгөө, сургалт, семинаруудыг тогтмол зохион байгуулсаар байна.

Харилцагч, даатгуулагчдынхаа цаг завыг хэмнэх, эрүүл мэндийг хамгаалах, даатгалын үйлчилгээг илүү ойр болгох үүднээс даатгал хийлгэх болон нөхөн төлбөрийн материал илгээх ажиллагааг Ард Аппаар шийдвэрлэдэг болов.

Ард Даатгал ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө бизнесийн ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна.

Монгол улсын 21 аймаг, 265 сумдад оршин суугаа иргэдэд санхүүгийн бүхий л төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, мэдээлэл түгээх зорилгын хүрээнд Ард Санхүүгийн Нэгдлээс хамтран хэрэгжүүлж буй "Ардын Брокер" төсөлд хамтран оролцлоо.

Хамт олны санаачлагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвд ажилчид цусаа хандивлалаа.

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард Даатгал ХК нь 2022 онд үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн 24 салбар нэгж, төлөөлөгчийн газар, системийн нөлөө бүхий 5 арилжааны банк, олон улсын болон дотоодын 70 гаруй брокер, мэргэжлийн оролцогч зуучлагч, олон тооны банк бус санхүүгийн байгууллага, 100 орчим даатгалын төлөөлөгчдөөрөө дамжуулан улс орон даяар даатгалын үйлчилгээг хүргэн ажиллалаа.

Ард Даатгал нь ердийн даатгалын компани бөгөөд албан журмын даатгалаас гадна сайн дурын 50 гаруй төрлийн даатгалын үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд санал болгож, IPO хийсэн анхны даатгалын компани бөгөөд жолоочийн даатгал, малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгалыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг билээ.

- Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал
- Эмчилгээний зардлын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Агаарын хөлгийн даатгал
- Ачаа тээврийн даатгал
- Бүх төрлийн хариуцлагын даатгал
- Ковидын даатгал
- Сэргээгдэх эрчим хүчний холбоотой даатгал
- Гадаадад зорчигчийн даатгал
- Санхүүгийн даатгал
- Жолоочийн хариуцлагын даатгал
- Газар тариалангийн даатгал
- Барилга угсралтын даатгал
- Малын индексжүүлсэн даатгал
- Сууц өмчлөгчдийн хариуцлагын даатгал
- Баталгааны даатгал
- Ногоон даатгал

Хүчтэй. Хамтдаа.

Ард Даатгал компани нь өнгөрсөн хугацаанд Монгол улсын өнцөг булан бүрт хүрч ажиллаж чадсан бөгөөд 2022 оны байдлаар нийтдээ 200 гаруй мянган даатгуулагчийг даатгалд хамруулаад байгаа төдийгүй үүнээс 2,000 гаруй байгууллагатай 15,000 гаруй гэрээ байгуулж улс орны баялаг бүтээж байгаа бүхий л салбарыг хамруулан даатгалын үйл ажиллагаагаа хүргэн ажиллаж байгаад компанийн хамт олон бахархаж байдаг юм. Тухайлбал :

- Дэд бүтэц, зам тээвэр, иргэний нисэх, агаарын тээвэр
- Барилга угсралт
- Үл хөдлөх хөрөнгө
- Эрчим хүч, уул уурхай, газрын тос
- Хөдөө аж ахуй
- Худалдаа үйлчилгээ
- Хөнгөн ба хүнд үйлдвэрлэл
- Батлан хамгаалах, цэрэг цагдаа, онцгой байдал
- Банк санхүү, даатгал
- Аялал жуулчлал, спорт
- Эрүүл мэнд
- Мэдээлэл технологи, харилцаа холбоо
- Төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагууд
- Эрдэм шинжилгээ, боловсрол, хууль эрх зүй
- Олон улсын байгууллага, Элчин сайдын яамдууд

Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа аж ахуйн нэгж, компаниудтай бид хамтран ажилладаг.

Компанийн хувьд харилцагч бүр үнэ цэнэтэй бөгөөд өнгөрсөн жил бид Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас эрэмбэлсэн ТОП-100 аж ахуйн нэгж байгууллагын 60 хувиас дээш хэсэг болох аж ахуйн нэгж байгууллагуудад шууд хэлбэрээр, дам хэлбэрээр 80 хувиас дээш хэсэгт нь, мөн 200 гаруй төрийн байгууллагуудад даатгалын үйлчилгээ үзүүлжээ.

Сүүлийн 3 жилийн байдлаар компанийн нийт хураамжийн орлогын бүтцийг авч үзвэл:

Тээврийн хэрэгслийн даатгал

Агаарын хөлгийн даатгал

Хариуцлагын даатгал

хураамжийн орлогын дийлэнх хэсгийг буюу **70%–80%** гаруй хувийг бүрдүүлсэн байна.

Хөрөнгийн даатгал

Жолоочийн хариуцлагын даатгал

Гэнэтийн осол эрүүл мэндийн даатгал

Барилга угсралтын ажлын даатгал

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Ард Даатгал компанийн хувьд Монгол Улсад дотоодод АрдМэнд, олон улсын хэмжээнд ArdMedicare (ArdMed) эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон амжилттай ажиллаж, давхардсан тоогоор 75 мянга гаруй харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай холбоотой даатгалын үйлчилгээ үзүүлж, харилцагчдын тоо өсөн нэмэгдлээ.

Хураамжийн орлого

АРД ТҮМНИЙ ЭРХЭМ БАЯЛАГ ЭРҮҮЛ МЭНД

2022 онд эрүүл мэндийн даатгалын баг хамт олон 3,128 даатгуулагчид 1.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

ArdMedicare олон улсын эрүүл мэндийн даатгал нь дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын MSH-үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллан, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм. MSH нь даатгалын компани, даатгуулагч-үйлчлүүлэгч, эмнэлгийн байгууллагыг холбох өгөх гүүр болдог.

Манай харилцагчдын хувьд олон улсын эрүүл мэндийн даатгалын шууд төлбөрийн үйлчилгээг (direct billing) Азийн улсууд болох БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол болон Австрали, Герман, Швед, Швейцарь зэрэг дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээр үйлчлүүлж авсан байна.

Эрүүл мэндийн даатгалын алба нь мэргэжлийн чадварлаг эмч нар, даатгалын мэргэшсэн мэргэжилтнүүдээр багаа өргөжүүлэн ажиллаж байна. Манай баг иргэдийн эрүүл мэндийн даатгалын боловсролд илүү анхаарч ажилласан бөгөөд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зэрэг мэдээлэл, сургалтуудыг мэргэжлийн эмч нартай хамтран 156 байгууллагад 4,680 хүнийг хамарсан сургалтыг уул уурхайн болон бусад ажлын байранд нь зохион байгуулсан байна.

Манай улсын эдийн засгийн гол тулгуур болсон уул уурхайн салбарын 2,000 орчим ажилтан, тэдгээрийн гэр бүлийг шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулж, амжилттай хамтран ажиллаж байна.

Салбар, орон нутгийн даатгалын үйл ажиллагаа

Ард Даатгал компани Монгол улсын аймаг бүрт салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2022 онд орон нутгийн салбарууд 2.35 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 22 хувийн өсөлтийг үзүүлжээ.

Тайлант хугацаанд Дархан-Уул болон Орхон аймгууд дахь салбарын үйл ажиллагааг өргөтгөн бүсийн төв болгосноор цаашид орон нутгийн ард иргэдэд, тухайн орон нутагт нь даатгалын бүх төрлийн цогц үйлчилгээг нэг доор үзүүлэх тохилог орчин бий болголоо.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 2022 оны 12 сарын 31-ний өдрийн тархалтын мэдээнээс харахад 9,515 хүрч хувьцаа эзэмшигчдийн тоо оны эхнээс 636 хувьцаа эзэмшигчээр буурсан бөгөөд буурсан шалтгаан нь хоёроос дээш ҮЦК-д бүртгэлтэй хувьцаа эзэмшигчид дансаа нэгтгэсэн, АСН-с гаргасан хувьцааны багцаар авсан хувьцаа эзэмшигчид зах зээлд нийлүүлсэн зэрэг нөлөөлсөн байна. Энэ онд хувьцаа эзэмшигчдийн дунд орсон томоохон өөрчлөлт нь Мандал Капитал Маркетс ҮЦК-ийн 5.1 хувь буюу 1,269,868 ширхэг хувьцаа эзэмшиж байсан бөгөөд зах зээлд бүрэн нийлүүлсэн бол Би Ди Сек ҮЦК компанийн 2.4 хувь буюу 599,216 ширхэг хувьцаа, Апекс Капитал ҮЦК-ийн 1.4 хувь буюу 358,524 ширхэг хувьцааг тус тус зах зээлээс авч эзэмшиж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

		2021.12.31		2022.12.31		Өөрчлөлт
		тоо	хувь	тоо	хувь	
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	11,338,675	45.4	11,342,832	45.4	4,157
2	Ардын Тэтгэврийн Данс ХХК	1,316,554	5.3	1,445,289	5.8	128,735
3	С.Оргил	1,164,822	4.7	1,164,822	4.7	-
4	Г.Бат-Эрдэнэ	1,164,822	4.7	1,164,822	4.7	-
5	Н.Мөнхнасан	1,140,742	4.6	1,140,742	4.6	-
6	Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.3	820,750	3.3	-
7	БиДиСек ҮЦК	10	0	599,216	2.4	599,206
8	Ард Кредит ББСБ ХК	368,983	1.5	437,006	1.7	68,023
9	Ард Бит ХХК	414,707	1.7	414,082	1.7	(625)
10	Апекс Капитал ҮЦК	-----	0	358,524	1.4	358,524
11	Үндэсний Хувьчлалын Сан ХОС	342,534	1.4	342,534	1.4	-
12	Бодь Даатгал ХК	212,594	0.9	212,594	0.9	-
13	А.Сүхдорж	203,994	0.8	203,994	0.8	-
14	Ч.Амарбаатар	186,614	0.7	166,000	0.7	(20,614)
15	Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК	1,269,868	5.1	----	0	(1,269,868)
16	Бусад	5,054,331	20.2	5,186,793	20.7	132,462
НИЙТ ДҮН		**25,000,000**	**100.0**	**25,000,000**	**100**	**-**
Хувьцаа эзэмшигчдийн тоо		**10,151**	**100.0**	**9,515**	**100**	**(636)**

Хувьцааны арилжааны хувьд 2022 онд 2.6 сая ширхэг хувьцаа, нийт 2.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд дээд үнэ 1,350 төгрөг, доод үнэ 685 төгрөг хүрсэн бол жилийн арилжааны сүүлийн өдөр 929 төгрөгөөр хаагдсан байна. Ингэснээр 2022 он жилийн эцсийн байдлаар компанийн үнэлгээ 23.2 тэрбум төгрөг болсон байна.

Хувьцааны арилжааны мэдээ



Хаалтын ханш	**₮929**	EPS:	₮36
Дээд болон доод ханш:	₮636 - ₮1,350	BVPS:	₮686
Нийт хувьцааны тоо:	25,000,000	P/E - Үнэ/Ашиг:	25.8
Нийт арилжаалагдсан тоо:	2.6 сая	P/B - Үнэ/Дансны үнэ:	1.35
Нийт арилжааны дүн:	₮2.4 тэрбум		
Зах зээлийн үнэлгээ:	₮23.2 тэрбум		

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид 2018 онд IPO хийж Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны 1-р ангилалд багтан анхдагч зах зээлийн захиалгаар 1,359 хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болсон ба 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар энэ тоо 9,515 болж өсөөд байна.

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана. Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилон ажиллаж байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2022 оны 4 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахаар шийдвэр гарсан бөгөөд тус шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж-39 хаягт байрлах Корпорэйт Зочид Буудал Конвеншн Центрийн хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. Тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн байна. Үүнд:

1. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2021 онд олгосон ногдол ашгийн тайлан танилцуулах;
3. 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэр:

1. Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дүгнэсэн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг батлав.
2. Хурлаас гарсан шийдвэр, холбогдох материалуудыг МХБ, СЗХ-нд хүргүүлэн зохих журмын хүрээнд ажиллалаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.
2021 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.
Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд нэг удаа эчнээгээр, таван удаа ээлжит хурал зохион байгуулсан бөгөөд хурлаар ногдол ашиг олгох тухай, ХЭХ хуралдуулах тухай, компанийн төсөв, улирал, жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан болон бусад цаг үеийн асуудлуудыг хэлэлцэж шийдвэрүүд гаргаж ажилласан байна. Мөн Ард Даатгал ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороотой байна.

2022 онд ТУЗ-ийн хувьд ээлжит болон эчнээ санал хураалт зэргийг хуваарийн дагуу амжилттай зохион байгуулж, зохих шийдвэрүүдийг гаргаж ажиллаа. Хурал болсон огноо:

1. 2022 оны 2 сарын 16-ны өдөр эчнээ (саналын хуудсаар)
2. 2022 оны 3 сарын 16-ны өдөр ээлжит
3. 2022 оны 4 сарын 27-ны өдөр ээлжит
4. 2022 оны 7 сарын 22-ны өдөр ээлжит
5. 2022 оны 10 сарын 26-ны өдөр ээлжит
6. 2022 оны 12 сарын 15-ны өдөр ээлжит

2022 онд ТУЗ-ийн бүтцэд өөрчлөлт орсон бөгөөд ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөж, ТУЗ-ийн гишүүн О.Одбаярыг ТУЗ-ын даргаар томилох шийдвэр гарсан. Мөн ТУЗ-ийн түр гишүүнээр Г.Уянга сонгогдож ажиллах шийдвэрүүд тус тус гарсан байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

ТУЗ-ийн дарга

Одончимэд
Одбаяр

ТУЗ-ийн гишүүн
Ард Санхүүгийн Нэгдэл ХК

Ердийн гишүүд

Галбадрах
Цогбадрах

Гүйцэтгэх захирал
Ард Даатгал ХК

Галням
Уянга

Гүйцэтгэх захирал
Ард Пропертиз ХХК

Батбилэг
Золбоо

Санхүү эрхэлсэн захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК

Чулуун
Ганзориг

Гүйцэтгэх захирал
Ард Экс ХХК

Сүхдорж
Оргил

Гүйцэтгэх захирал
Мост Финтек ХХК

Хараат бус гишүүд

Зоригт
Ариун

Төслийн удирдагч
Занаду Резиденс

Баатарзоригт
Болорчимэг

Үүсгэн байгуулагч
Өрөг.МН

Ичинхорлоо
Сэр-Од

Захирал
Монголын бизнес мэдээллийн бааз

НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

2021 оны цэвэр ашгаас ногдол ашиг олгох тухай шийдвэрийг 2022 оны 2 сарын 16-ны өдөр ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрээр 2021 оны цэвэр ашгаас нийт 1 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2022 оны 7 сарын 28-ны өдөр ҮЦТХТ-тэй ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ дэх хувьцааны дансаар дамжуулан ногдол ашгийг бүрэн олголоо.
Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2022 оны 4 сарын 4-ний байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийг эрт илрүүлэх, үнэлэх, удирдахын тулд дотоодын болон зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлүүдийг тооцоолж компанийн эрсдэлийн хороо болон төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол танилцуулах замаар хяналтын болон гүйцэтгэлийн тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр бидэнд эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, оновчтой удирдах, цаашлаад өөрийн давсан эрсдэлийг давхар даатгалд шилжүүлэн ажиллах боломжийг олгож байна.

Харьцаа үзүүлэлт



LR (хохирлын харьцаа) = Нөхөн төлбөрийн цэвэр зардал / Даатгалын хураамжийн цэвэр орлого
ER (зардлын харьцаа) = Үйл ажиллагааны зардал / Даатгалын хураамжийн цэвэр орлого
CR (хосолсон харьцаа) = LR + ER

Даатгалын андеррайтинг нь компанийн эрсдэлийн түвшин, ашигт ажиллагааг үнэлэх үйл ажиллагаа юм. Ингэхдээ андеррайтингийн голлох үзүүлэлтүүд болох хохирлын, зардлын болон хосолсон харьцаануудыг ашигладаг.

Төлбөрийн чадвар

Тайлант хугацаанд төлбөрийн чадварын зохистой харьцаа 118% гарсан ба даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө, төлбөрийн чадвартай байна.

Нөөц сан

Нөөц сан нь даатгалын компани нийт даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд зориулж байгуулсан мөнгөн хөрөнгө юм. 2022 оны эцсээр 3.13 тэрбум төгрөгийн нөөц сан байгуулсан нь дараагийн улирлын нөхөн төлбөрт хүрэлцээтэй байхаар байгуулсан болно. Нөөц сангийн хэмжээ жил бүр өссөн байгаа нь компанийн даатгуулагчийн өмнө хүлээх хариуцлагын чадамж хүчтэй байгааг харуулж байна.

ДАВХАР ДААТГАЛ

Ард Даатгал ХК нь 2022 онд 23 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан ба үүний 4.2 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын компаниудад шилжүүлж эрсдэлээ тараан байршуулсан бөгөөд өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал давхар даатгалын хураамж 2 дахин өссөн байна. Энэ нь өмнөх жилийн Ковид 19 цар тахлын үеийн сул байсан эдийн засаг 2022 онд харьцангуй сэргэсэн, бүтээн байгуулалт эхэлсэнээс үүдэн барилга угсралтын төслийн даатгал үлэмж хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой.

Давхар даатгалын хэлбэр */сая төгрөг/*

Даатгалын хэлбэр	2021 он		2022 он	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	564,0	25.7	481,4	11,4
Хөрөнгийн даатгал	666,9	30.4	1,748,8	41.3
Ачааны даатгал	40,4	1.8	34,8	0.8
Барилга угсралтын даатгал	334,6	15.3	1,588,7	37.6
Мал амьтдын даатгал	67,9	3.1	95,9	2.3
Хариуцлагын даатгал	449,5	20.5	162,2	3.8
Санхүүгийн даатгал	70,3	3.2	118,6	2.8
Нийт	**2,194**	**100**	**4,230**	**100**

Давхар даатгалын төрлөөр авч үзвэл нийт давхар даатгалын хураамжийн 41.2 хувийг факультатив, 37.7 хувийг фронтинг, 21 хувийг трити эзэлж байна.





Ард Даатгал ХК-ийн давхар даатгуулсан эрсдэлийн 52.6 хувийг Европын зах зээл, 42.4 хувийг Азийн зах зээл, 4.9 хувийг Монгол улсын давхар даатгалын зах зээлд эрсдэлийг тараан байршуулж ажилласан байна.

НӨХӨН ТӨЛБӨР

2021 онд Ард Даатгал ХК нь нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 5,608 даатгалын тохиолдолтой холбоотой 4.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж байсан бол 2022 онд 7,675 даатгалын тохиолдолтой холбоотой 7.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ

Даатгалын хэлбэр	2021 он			
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,017.41	20	1,303	17
Ачааны даатгал	407.0	8	96.3	1
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	963.2	19	1,726.2	22
Жолоочийн хариуцлагын даатгал	1,197.1	24	2,532.6	32
Зээлийн даатгал	551.28	11	1,617.5	21
Хариуцлагын даатгал	317.7	6	75.1	1
Хөрөнгийн даатгал	2,777	6	77.8	1
Бусад	235.3	5	430.5	5
Нийт дүн	**4,966.7**	**100**	**7,859.1**	**100**

Нийт олгосон нөхөн төлбөрийн тоог даатгалын хэлбэрээр задлан харуулбал авто тээврийн хэрэгслийн даатгал 17 хувь буюу 1,333 нэхэмжлэл, жолоочийн даатгал 32 хувь буюу 2,717 нэхэмжлэл, хөрөнгийн даатгал 2 хувь буюу 100 нэхэмжлэл, үлдсэн хэсэг нь ачааны даатгал, гэнэтийн осол эмчилгээний даатгал, зээлийн даатгал, хариуцлага бусад хэлбэрийн даатгалд тус тус хамаарахаар байна.

2022 оны хувьд нэгж нэхэмжлэлийн хэмжээ 1,036.7 мянган төгрөг болж дунджаар өмнөх оноос 58,725 төгрөгөөр өссөн байна.

2021 онд нийт 2,995 ослын дуудлага хүлээн авч 1,364 даатгалын тохиолдлыг ослын газарт үзэж баталгаажуулсан бол 2022 оны тайлант хугацаанд 3,991 ослын дуудлага хүлээн авснаас 2,042 даатгалын тохиолдлыг ослын газарт үзэж баталгаажуулсан байна.

ХҮНИЙ НӨӨЦ

ХҮНИЙ НӨӨЦ

Ард Даатгал ХК нь 2022 оны байдлаар дунджаар 92 үндсэн ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явууллаа. Үүнээс төв оффис дээр 51, орон нутагт 41, үүнээс хүүхэд асрах хугацааны чөлөөтэй 3 ажилтан, мөн хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй 1 ажилтан байна.



Ажлын байрны сул орон тоон дээр тухай бүрт нь шалгаруулалтыг явуулж 2022 онд нийт 27 хүн шинээр ажилд авсан. Мөн оны хувьд гүйцэтгэл хангалтгүй ажилласан болон Хөдөлмөрийн үйл ажиллагааны дотоод журмыг зөрчсөн үйлдэл гаргасан, мөн өөрийн хүсэлтээр, эрүүл мэндийн шалтгаан, ар гачигдал гэх мэт бусад шалтгаанаар нийт 34 хүн ажлаас чөлөөлөгдсөн байна.

Сургалт

- Нийт ажиллагсдын идэвх, ур чадвар, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотоод сургалтыг явуулах болсонтой холбогдуулан "Оновчтой шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлс" сэдвээр сургалт зохион байгуулав.
- Орон нутгийн салбаруудын ажиллагсдын чадавхийг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох зорилготойгоор уламжлал болгон зохион байгуулдаг Бид Манлайлна уулзалт сургалтыг 21 аймгийн 44 ажиллагсдыг хамруулан амжилттай зохион байгуулсан.
- Байгууллагын сэтгэл зүйн менежмент болон Багийн дүрийн удирдлага сэдвүүдээр үечилсэн сургалтуудыг танхимаар зохион байгуулж, нийт ажиллагсдыг хамруулав.
- Борлуулалтын ажиллагсдын ур чадварыг нэмэгдүүлэх, шинэ ажиллагсдыг чиглүүлэх дотоод сургалтуудыг сар бүр 2 удаа зохион байгуулж тогтмолжуулав.
- Борлуулалт хийх арга зүй, борлуулалтын дараах эргэх холбоо сэдвээр танхимын сургалтыг зохион байгуулж, даатгалын газрын ажиллагсдыг сургалтанд хамруулсан.
- Нөхөн төлбөрийн албаны ажиллагсдыг Хохирол үнэлгээчдийн холбооноос БНСУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулдаг Эрүүл мэнд, гэнэтийн ослын хохирол үнэлгээний аргачлал, зааварчилгаа сэдвээр танхимын 3 өдрийн 20 цагийн сургалтанд хамруулж сертификатыг гардан авсан.
- IT лабораторитой хамтран Дархлаа гэж юу вэ? сэдвээр танхимын сургалтыг зохион байгуулж, компанийн нийт ажиллагсдыг хамруулан ажиллалаа.

2022 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

GrantThornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Ард Даатгал ХК (цаашид "компани" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Ард Даатгал ХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан дүрэм журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

GrantThornton

Аудитын аргачлалын хураангуй

Материаллаг байдал	• Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 352,319 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт хөрөнгийн 1%, даатгалын үйлчилгээний цэвэр орлогын 2%-иар тооцсон. • Компани нь олон нийтэд хувьцаагаа арилждаг буюу олон нийтийн ашиг сонирхлын компани, мөн ашгийн хувьд өндөр хэлбэлзэлтэй зэрэг шинж чанаруудыг харгалзан нийт хөрөнгө болон даатгалын үйлчилгээний цэвэр орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тус тус сонгосон. Компанийн ажилчдаас авсан асуулгын үр дүн, өмнөх аудитын зөвлөмж, зохицуулагч байгууллагын тайланд үндэслэн эрсдэлийг дундаж гэж үнэлэн хувь хэмжээг 1%, 2%-иар тогтоолоо.

Онцлох асуудал

"Ард даатгал" ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн Сайдын "Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал батлах тухай" 2020 оны 07 сарын 07-ны 132 дугаар тогтоолоор батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэж, толилуулсан.

Энэхүү заавар нь СТОУС, НББ-ийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд дансдын нийтлэг бичилтүүдийг үзүүлж, зааварт тусгагдаагүй зүйлсийг бүртгэхдээ холбогдох СТОУС-ын заалт болон Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж ажиллахыг шаарддаг.

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан даатгалын багц дүрмийг тууштай мөрдөнө.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Grant Thornton

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.
Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг

www.grantthornton.mn

Grant Thornton

үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Сангийн сайдын журам болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Төлбөрийн чадварын талаар

Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 118.65% (2021: 115.97%) байгаа нь Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.18-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэснийг хангасан байна.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.

GRANT THORNTON AUDIT LLC

Б.ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

2023 оны 3 дугаар сарын 31

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8	814,417	983,100
Даатгалын авлага	9	5,638,403	3,567,406
Бусад санхүүгийн хөрөнгө	10	752,084	1,712,440
Бусад санхүүгийн бус хөрөнгө	11	548,452	946,715
Хөрөнгө оруулалт	12	24,181,282	23,609,898
Даатгалын хөрөнгө	13	3,091,172	1,924,247
Үндсэн хөрөнгө (цэвэр)	14	405,608	2,082,238
Биет бус хөрөнгө (цэвэр)	15	213,093	-
Нийт хөрөнгө		**35,644,511**	**34,826,044**
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Даатгалын өглөг	16	2,220,430	2,265,356
Бусад санхүүгийн өр төлбөр	17	694,789	941,160
Бусад санхүүгийн бус өр төлбөр	18	1,345,534	1,515,332
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	19	11,569,702	8,307,000
Нөхөн төлбөрийн нөөц сан	20	3,134,774	3,401,350
Өр төлбөрийн нийт дүн		**18,965,229**	**16,430,198**
Эздийн өмч			
Эзэмшигчдийн өмч	21	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал		3,280,854	3,280,854
Дахин үнэлгээний нэмэгдэл		(267,492)	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		8,665,920	10,114,992
Эздийн өмчийн дүн		**16,679,282**	**18,395,846**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		**35,644,511**	**34,826,044**

Уг санхүүгийн байдлын тайланг 2023 оны 3 дугаар сарын 31-нд батлав:

Гүйцэтгэх захирал
Г. Цогбадрах
Огноо: 2023/03/31

Санхүү удирдлага, үйл ажиллагааны газрын захирал
Т.Батцэнгэл
Огноо: 2023/03/31

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

7

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Даатгалын үйл ажиллагаа			
Даатгалын хураамжийн нийт орлого	22.1	22,315,689	16,462,353
Даатгалын хураамжийн буцаалт	22.2	468,805	570,234
Давхар даатгалын хураамжийн зардал	22.3	4,230,922	2,398,880
Даатгалын хураамжийн цэвэр орлого		**17,615,962**	**13,493,239**
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	23	(3,262,702)	(616,900)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	24	662,283	(1,183,631)
Орлогод тооцсон хураамж		**15,015,543**	**11,692,708**
Нийт нөхөн төлбөрийн зардал	25.1	7,858,896	4,966,724
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	25.2	254,590	336,403
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	25.3	1,574,204	481,603
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		**6,030,102**	**4,148,718**
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	26.1	(244,479)	(4,307)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	26.2	(10,437)	397,693
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	26.3	(22,097)	284,729
Зардалд тооцсон нөхөн төлбөр		**5,753,089**	**4,826,833**
Даатгалын гэрээний зардал	27	2,590,349	2,153,743
Давхар даатгалын шимтгэлийн орлого	28	143,467	178,127
Хөренгө оруулалтын орлого ба олз (гарз)	29	435,828	9,294,759
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)		**7,251,399**	**14,185,018**
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		-	370
Бусад орлого	30	191,590	153,227
Ерөнхий ба удирдлагын зардал	31	2,355,406	2,079,967
Борлуулалт, маркетингийн зардал	32	3,796,194	3,532,465
Санхүүгийн зардал	33	13,785	41,590
Бусад зардал	34	202,222	465,276
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	35	(226,860)	4,334
Биет болон биет бус хөренгө данснаас хассаны олз (гарз)		54,106	98,257
Бусад ашиг (алдагдал)		**(6,348,771)**	**(5,863,110)**
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		**902,629**	**8,321,908**
Орлогын татварын зардал	36	165,973	1,145,928
Татварын дараах ашиг (алдагдал)		**736,656**	**7,175,980**

8

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Бусад дэлгэрэнгүй орлого		
Үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	(267,492)	-
Нийт дэлгэрэнгүй орлогын нийт дүн	**469,164**	**7,175,980**
Нэгж хувьцаанд ногдох ашиг	0.019	0.29

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

9

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**5,000,000**	**3,280,854**	**-**	**5,018,128**	**13,298,982**
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,079,115)	(1,079,115)
Залруулсан үлдэгдэл	**5,000,000**	**3,280,854**	**-**	**3,939,013**	**12,219,867**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	7,175,980	7,175,980
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,000,000)	(1,000,000)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**5,000,000**	**3,280,854**	**-**	**10,114,993**	**18,395,847**
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,185,730)	(1,185,730)
Залруулсан үлдэгдэл	**5,000,000**	**3,280,854**	**-**	**8,929,263**	**17,210,117**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	736,657	736,657
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,000,000)	(1,000,000)
Үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	(267,492)	-	(267,492)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**5,000,000**	**3,280,854**	**(267,492)**	**8,665,920**	**16,679,282**

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

10

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		**26,846,330**	**18,269,052**
Даатгалын хураамжийн орлого		20,416,387	14,778,490
Давхар даатгалын нөхөн төлбөр		79,384	-
Бусад мөнгөн орлого		6,350,559	3,490,562
Мөнгөн зарлагын дүн		**25,685,417**	**17,754,044**
Ажиллагчдад төлсөн		1,680,673	1,353,791
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		474,863	413,520
Бараа материал худалдан авахад төлсөн		278,149	137,044
Ашиглалтын зардалд төлсөн		36,795	7,484
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		4,732,150	942,490
Үүнээс: Сайн дурын даатгалын		4,927,996	3,153,640
Албан журмын даатгалын		2,408,784	1,152,898
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		1,925,532	1,494,058
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр		1,159,115	763,959
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн		53,726	44,160
Хүүний төлбөрт төлсөн		11,525	2,052
Татварын байгууллагад төлсөн		1,158,830	764,169
Даатгалын төлбөрт төлсөн		32,933	27,417
Бусад мөнгөн зарлага		6,804,346	7,497,362
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**1,160,913**	**515,008**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		**6,665,261**	**8,139,680**
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого			-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		6,446,867	6,282,768
Хүлээн авсан хүүний орлого		164,428	1,799,186
Хүлээн авсан ногдол ашиг		53,966	57,726

11

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (ееребр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Мөнгөн гүйлгээний тайлан
(үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Мөнгөн зарлагын дүн		**7,577,826**	**7,934,082**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		7,942	239,526
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		7,569,884	7,694,556
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**(912,565)**	**205,598**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн зарлагын дүн		**437,789**	**915,374**
Төлсөн ногдол ашиг		437,789	915,374
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**(437,789)**	**(915,374)**
Валютын ханшийн зөрүү		20,758	1,274
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		**(168,683)**	**(193,494)**
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	8	**983,100**	**1,176,594**
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8	**814,417**	**983,100**

Хуудас 13- 54-д харуулсан тодруулгууд нь энэхүү мөнгөн гүйлгээний тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

12

Хүчтэй. Хамтдаа.